



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/526

Ховд

Шүүхийн шийдвэртэй өр барагдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны "Аймгийн 2022 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай" 7/02 дугаар тогтоол, аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 154/ШШ2022/00108 дугаартай шийдвэрийг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөвт байгууллагуудад дулаан халаалтын үйлчилгээг үзүүлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын эрх бүхий байгууллагаас баталсан төлбөрийн үнэлгээгээр тооцсон халаалтын хөлс болон дулаан ашиглагч төсөвт байгууллагуудын жил бүрийн халаалтын батлагдсан төсвийн зөрүүгээс үүссэн Үенч сумын төсөвт байгууллагуудын "Мирай кэнсэцү" ХХК-д төлүүлэх өрийн тухай аймгийн Булган сум дахь сум дундын шүүхээс шийдвэрлэсэн 257,249,351 төгрөг (хоёр зуун тавин долоон сая хоёр зуун дөчин есөн мянга гурван зуун тавин нэг)-ийг хавсралтаар баталж халаалтын өрийг барагдуулахаар зарцуулсугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 257,249,351 төгрөг (хоёр зуун тавин долоон сая хоёр зуун дөчин есөн мянга гурван зуун тавин нэг)-ийг аймгийн Засаг дарга дансанд 2022 онд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2653  
Zah A/526 Bo

Аймгийн Засаг даргын 2022 оны  
08 дугаар сарын 16-ны өдрийн  
А/526 дугаар захирамжийн хавсралт



ҮЕНЧ СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН  
ХАЛААЛТЫН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЖАГСААЛТ

Д/Д	Хүлээн авах байгууллагын нэр	Шүүхийн шийдвэрийн он сар, өдөр, дугаар	Төлбөр тооцогдох он, сар	Нийт дүн / төгрөгөөр/
1.	Үенч сумын эрүүл мэндийн төв	2022.05.18 154/ШШ2022/00112	2021 он	10656142.00
2.	Үенч сумын ЕБСургууль	2022.06.07 154/ШШ2022/00129	2021 он	223540494.00
3.	Үенч сумын хүүхдийн цэцэрлэг	2022.05.13 154/ШШ2022/00108	2021 он	23052715.00
	Дүн			257249351.00

-оОо-